



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 5/12

Чингис хот

Б.Цэцэгмаагийн албан тушаалын
зэрэглэлийг ахиулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, 2016 онд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авч, Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/59, 2019 оны А/47 дугаар тушаалаар нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчаар томилогдсон Балдангомбын Цэцэгмаагийн албан тушаалын зэрэглэлийг ахиулан 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн олгосугай.

2. Б.Цэцэгмаагийн цалинг ТЗ-6-4 шатлалаар тогтоон, үндсэн цалинг 813215 /найман зуун арван гурван мянга хоёр зуун арван тав/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Г.Ариунхүү/-д зөвшөөрсүгэй.

3. Б.Цэцэгмаад томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, эрх бүхий албан тушаалтан /Ж.Гантулга/-д гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030052